2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,591,447.80	1,465,788.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,570,851.80	1,450,192.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,085,990.80	1,025,998.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,668.10	611,695.13
210101	Үндсэн цалин	442,780.60	446,487.26
210102	Нэмэгдэл	77,725.50	77,693.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	26,173.20	22,340.46
210105	Гэрээт ажлын хөлс	73,988.80	65,174.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,465.70	66,619.05
210201	Тэтгэврийн даатгал	46,232.60	46,102.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,308.60	5,129.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,246.20	4,103.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,061.50	1,025.90
210205	Эрүүл мэндийн даатгал	10,616.80	10,258.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,609.20	182,609.20
210301	Гэрэл, цахилгаан	27,913.20	27,718.99
210302	Түлш, халаалт	152,996.00	153,190.21
210303	Цэвэр, бохир ус	1,700.00	1,700.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	35,145.60	23,932.80
210401	Бичиг хэрэг	2,066.10	2,021.00
210402	Тээвэр, шатахуун	30,380.80	19,262.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,610.70	2,561.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88.00	88.00

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	457.00	457.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457.00	457.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,739.70	13,722.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	100.00	83.00
210604	Урсгал засвар	13,639.70	13,639.70
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,241.10	6,174.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	6,241.10	6,174.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,245.20	10,207.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,894.20	8,867.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	414.30	414.30
210803	Даатгалын үйлчилгээ	90.30	90.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184.90	184.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75.00	75.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	441.80	434.70
210807	Газрын төлбөр	37.30	37.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11.50	10.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	95.90	94.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	144,419.20	110,581.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	143,621.40	109,828.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	797.80	753.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	484,861.00	424,193.65
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	461,830.40	401,163.05
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	461,830.40	401,163.05
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,030.60	23,030.60
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,030.60	23,030.60
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,596.00</b>	<b>15,596.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	20,596.00	15,596.00
223001	Бусад хөрөнгө	20,596.00	15,596.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,591,447.80	1,445,339.31
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,310,822.90	1,357,205.37
132001	Орон нутгийн төсвөөс	950,414.70	996,797.17
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	360,408.20	360,408.20
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	280,624.90	88,133.94
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000.00	88,133.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	200,624.90	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		140,531.24
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		120,082.33

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,390.60

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,390.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,390.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,390.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,390.60
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,390.60
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,390.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,147.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,243.60

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Ногооннуур сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд “хөрөнгө оруулалтыг сумын хөгжилтэй уялдуулах замаар ард түмний санал санаачилгад тулгуурлан хэрэгжүүлснээр нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, аймгийн Загвар сум болгох” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

*Дээрх зорилтын хүрээнд доорх дэд зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.*

Үүнд:

- Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх
- Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах
- Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах
- Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Ногооннуур сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тус албанаас Ногооннуур сумын зарим төсөвт байгууллагуудын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,016.6 сая төгрөгөөр буюу 50.6 хувиар буурсан байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	273,777.7	502,777.2	228,999.5
Авлага	300,457.2	217,019.2	(83,438.0)
Урьдчилгаа			-
Бараа материал	501,784.1	67,058.0	(434,726.1)
Үндсэн хөрөнгө	8,844,666.1	4,117,171.7	(4,727,494.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,920,685.0</b>	<b>4,904,026.1</b>	<b>(5,016,658.9)</b>
Өр төлбөр	40,822.3	56,757.8	15,935.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	9,879,862.8	4,847,268.3	(5,032,594.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>9,920,685.0</b>	<b>4,904,026.1</b>	<b>(5,016,658.9)</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдлээс 229.0 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн орлогын давсан хэсгийн дансны үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 83.4 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлага 3.0 сая, төлбөртэй үйлчилгээний авлага 43.7 сая, байгууллагаас авах авлага 15.0 сая, хувь хүмүүсээс авах авлага 6.7 сая, зээлийн авлага 15.0 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бараа материалын данс 434.7 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө данс 4727.5 сая төгрөгийн тус тус буурсан нь боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны оны эхний 15.9 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2.1 сая, Засаг даргын тамгын газрын 18.1 сая төгрөгийн, Орон нутаг хөгжүүлэх сангийн 36.5 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд 5016.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 5016.6 сая төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд Ногооннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1591.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1570.8 сая төгрөгийг урсгал зардалд, 20.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 950.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 360.4 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 80.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 200.6 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Ногооннуур сум нь 2022 онд гүйцэтгэлээр нийтдээ 1445.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс орон нутгийн төсвөөс 996.8 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 360.4 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 88.1 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвөөс 0.2 сая төгрөгийн төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс 46.4 сая төгрөгийн санхүүжилтийг илүү авч, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/ 8.1 сая төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 146.1 сая төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

#### **Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 88.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүний 88.1 сая төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аймгийн ИТХ-ын 2021 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 51 дугаар тогтоолоор Ногооннуур сумын 2022 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 390.0 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2022 оны 95 дугаар тодотголоор 12 сая төгрөгөөр нэмэгдүүлж 402.0 сая төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 40 дүгээр хуралдааны тогтоолоор 2022 орлогын төлөвлөгөөг 402.0 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогод 717.4 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 317.9 сая төгрөгөөр буюу 83 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/*

<u>Үзүүлэлт</u>	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	392,531.8	676,485.4	286,453.6	94.3
II.Татварын бус орлого	9,500.0	40,950.1	318450.1	5.7
<b>Нийт дүн</b>	<b>402,031.8</b>	<b>717,435.5</b>	<b>317,903.7</b>	<b>100</b>

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд татварын орлогоос үйл ажиллагааны орлогын албан татвар 65.6 сая, хөрөнгийн орлогын албан татвар 34.0 сая, бууны албан татвар 2.2 сая төгрөгөөр, газрын төлбөр 10.1 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамж 4.1 сая, хог хаягдлын хураамж 8.9 сая, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр 1.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Цалин хөлсний орлого 80.2 сая, хөрөнгө борлуулсны орлогоос 4.5 сая, улсын тэмдэгтийн хураамж 27.1 сая, агнуурын нөөцийн төлбөрөөс 287.4 сая, хүү торгуулийн орлого 18.8 сая төгрөг давж биелэгдэж, төлөвлөгөө өгөгдөөгүй малын татвараас 13.5 сая төгрөгийн орлого орсон нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэгдэхэд нөлөөлсөн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 117.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 676.5 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 0.2 сая төгрөгийн санхүүжилтийн төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 364.1 сая төгрөгийн, байгаль хамгаалах сангийн 15.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

*Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар: /сая төгрөг/*

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	120,963.40	73,356.30	47,607.10
2	Сумын ЗДТГ	542,360.60	542,360.60	0.00
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	179,001.00	179,001.00	0.00
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	27,091.90	27,091.90	0.00
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	25,337.30	25,337.30	0.00
6	Ерөнхий боловсролын 4-р сургууль	29,639.50	29,639.50	0.00
7	Хүүхдийн 1-р цэцэрлэг	43,555.50	43,555.50	0.00
8	Хүүхдийн 2-р цэцэрлэг	60,907.80	60,694.60	213.20
9	Соёлын төв	15,358.30	15,358.30	0.00
10	Эрүүл мэндийн төв	26,340.70	26,340.70	0.00
11	ОНХСан	440,891.80	375,224.50	65,667.30
12	СХС	80,000.00	67,828.00	12,172.00
	<b>Нийт дүн</b>	<b>1,591,447.80</b>	<b>1,465,788.20</b>	<b>125,659.60</b>

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1.1 сая төгрөгийн, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 3.3 сая төгрөгийн нийт 4.4 сая нэмэлт санхүүжилт хүлээн авч бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 3 дүгээр сарын 03-ны өдрийн 32 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,803.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 102.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад сумын Засаг даргын тамгын газар нь нийт 9 орон тоог илүү ажиллуулж 47.8 сая төгрөгийн, шүүхийн шийдвэрээр нөхөн сонгуулийн зардалд 5.7 сая төгрөгийн үргүй зардал гаргаж, тайлант оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн 6.2 сая, хувь хүний орлогын албан татварын 11.9 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Тус аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 2022 оны 1-9 сарын мэдээллийг хамруулан шалгасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн албаны зөвлөлийн 2019.07.16-ны өдрийн 42 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан сумын Санхүүгийн албаны ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн 2 дугаар гарын үсгийг санхүүгийн албаны даргаар зуруулж, тайлан, баланс гаргуулах, зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					-
Албан шаардлага					

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөвлөмж	1	0	1	0	100.00
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.00</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газарт “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 71.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 71.6 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Ний алдаа зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сумын ИТХ	-	-								
2	Сумын ЗДТГ	1	71,625.70					1	71,625.70		
8	ОНХСан	-	-								
9	СХС	-	-								
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>71,625.70</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>1</b>	<b>71,625.70</b>	<b>0</b>	<b>0.00</b>

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй байна.

#### 1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Ногооннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>										